



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2025 оны III улирлын тайлан

СОХОРСОН БИШ ЗАВШИВ

Сохорсон биш завшив

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 хувиар нэмэгдлээ. Иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт саарч байгаа боловч бизнесийг дэмжихэд чиглэсэн зээл олголт өсөлттэй хэвээр байна. Банкны салбарын олгосон 20 зээл тутмын 1 нь чанаргүй байна. Инфляцын түвшин харьцангуй тогтвортой байсан тул төгрөгийн хадгаламжийн өгөөж, валютын хадгаламжийн өгөөжөөс өндөр хэвээр байна.

Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан 8 улирал дараалан унаад байсан хөдөө аж ахуйн салбарын сэргэлт нь эдийн засгийн өсөлтийн дийлэнх хэсгийг бүрдүүллээ. Боловсруулах, барилгын салбарын аажим сэргэлт нь эдийн засгийн өсөлтийг дэмжиж өглөө. Уул уурхайн салбарын өсөлт хүлээлтээс доогуур байсны улмаас түүнийг дагасан тээвэр, худалдааны салбарын өсөлт саарч эдийн засгийн өсөлтийг хойш татав.

Оны эхнээс эрдэс бүтээгдэхүүн тэр дундаа нүүрсний үнийн бууралтаас шалтгаалан экспорт буурсан бол нөгөө талдаа авто машины болон хэрэглээний зориулалттай бараа бүтээгдэхүүний импорт өсөлттэй байлаа.

Урсгал дансны алдагдал нь төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэхэд нөлөөлсөн бол гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулахад чухал нөлөө үзүүлжээ. Төсвийн үндсэн тэнцэл ашигтай гарч төсөвт ирэх дарамтыг бууруулж байна.

Энэ оны төсвийг батлахдаа түүхий эдийн үнэ болон тоо хэмжээг хэт их өөдрөг төсөөлж, зөвхөн нүүрсний үнэнд найдаад, эрдэс бүтээгдэхүүний төрөлжилт багатайгаар зарлагыг нэмэгдүүлсэн. Сөрөг үр дагавар авчирал шийдвэр нь эдийн засаг өсөлттэй гарсан энэ цаг үед **сохорсон биш завшив** гэдгийн адил үйл явдал боллоо.



Банкуудын иргэдэд олгож буй зээлийн өсөлт саарч байна.

Хэрэглээний зээл буюу цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт саарлаа.
Малчдад олгосон зээлийн хэмжээ нэг дахин нэмэгджээ.


Онцлох өөрчлөлт,
энгийн тайлбар



Онолын тодорхойлолт



Иргэдийн зээл олголт, жил бүрийн III улирал



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Шинээр олгосон зээлийн хэмжээ нэмэгдэв.

8%



2025 оны III улирлын
гүйцэтгэл

2025 ОНЫ III УЛИРАЛД БАНКНЫ САЛБАРТ ГАРСАН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Банкуудын зээлийн өсөлтийн эрч саарч байна.



Банкуудын чанаргүй зээлийн хэмжээ бага түвшинд байна



Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж 20%-тай байна.



Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн үзүүлэлт өсөлттэй байна.



Банкуудын хувьцааны ханш тогтмол өсөлттэй байна.



Төгрөгийн хадгаламжийн өгөөж валютын хадгаламжийн өгөөжөөс өндөр байна.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны III улирал

Банкны салбарын зээлийн өсөлтийн эрч саарч байна.

Эдийн засгийн өсөлт үргэлжлэхийн зэрэгцээ түүнийг дагаад бизнесүүдэд олгох зээл нэмэгджээ. Иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт саарч эхэлжээ.


Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.

+22%

Зээлийн үлдэгдэл
нэмэгджээ.


Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо



Эдийн засгийн салбаруудыг дэмжсэн бизнесийн зээл олголт өсөлттэй хэвээр байна.

Уул уурхай, боловсруулах болон барилгын салбаруудад олгох зээлийн хэмжээ нэмэгджээ. Худалдаа, үйлчилгээний салбарт олгож буй зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Бизнесийн зээл олголт, жил бүрийн III улирал



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Шинээр бизнесүүдэд олгосон зээл

18%

нэмэгджээ.

Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд
чанаргүй зээл

5.2%

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо


Банкны салбарын 20 зээл тутмын нэг нь чанаргүй байна.

Хэрэглээний зээлийн чанаргүйдэл аажмаар нэмэгдэж байна.


Бизнесийн идэвхжил нэмэгдсэн нь чанаргүй зээлийн хэмжээг буурахад чухал нөлөө үзүүлээ.

Бизнесийн 10 зээл тутмын нэг нь чанаргүй байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн III улирал



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн III улирал



Иргэдийн хугацаатай хадгаламжид итгэх итгэл нэмэгджээ.

Валютын харилцах 5 хувиар, валютын хадгаламж 20 хувиар тус тус нэмэгджээ.
Төгрөгийн харилцах 14 хувиар буурсан бол төгрөгийн хадгаламж 14 хувиар нэмэгдэж хугацаатай хадгаламжид итгэх иргэдийн итгэл нэмэгджээ.

Банкны эх үүсвэр
Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Их наяд ₮

Банкны эх үүсвэр, жил бүрийн III улирал



Банкны эх үүсвэр
5.9%
нэмэгджээ.

Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.


Хадгаламжийн хүү

11.9%

Эх сурвалж: Монголбанк

Хүүгийн түвшин тогтвортой байна.

Төв банк гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан мөнгөний хатуу бодлого баримталж буй хэдий ч хүүгийн түвшин харьцангуй тогтвортой байна.



БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны III улирлын гүйцэтгэл

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий
банкнуудын актив


20%

ӨСӨВ.

Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 11 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

ХХБ, Хас банкны актив тус бүрий 26 хувиар нэмэгдэж банкны салбарын активын өсөлтөд чухал нөлөө үзүүллээ. Голомт банкны актив 25 хувиар, Төрийн банкны актив 22 хувиар, Хаан банкны актив 9 хувиар нэмэгдсэн нь банкны салбарын өсөлтийг хадгалахад чухал нөлөө үзүүллээ.

Банкуудын актив жил бүрийн III улиралд



Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Голомт банкны эх үүсвэр 21 хувиар, ХХБ-ны эх үүсвэр 18 хувиар, Төрийн банкны эх үүсвэр 14 хувиар, Хасбанкны эх үүсвэр 11 хувиар тус тус нэмэгджээ.
Хаан банкны эх үүсвэр 1 хувиар буурчээ.



Банкны эх үүсвэр
Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкуудын эх үүсвэр

10%

НЭМЭГДЖЭЭ.

Өөрийн хөрөнгийн өгөөж

Жич: Тухайн байгууллага нь өөрийн хөрөнгөө хэр үр ашигтай зарцуулж буй тухай мэдээлэл өгдөг. Өөрөөр хэлбэл компани хөрөнгийг хэрхэн ашиг болгож буйг илэрхийлдэг үзүүлэлт юм.

Банкуудын өөрийн
хөрөнгийн өгөөж дунджаар


14%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж хадгаламжийн өгөөжөөс илүү байна.

Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн дүн 7.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 15 хувиар өсжээ. Өөрийн хөрөнгөөр бий болгосон ашгийн хэмжээ өндөр хэвээр байна.


Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж, жил бүрийн III улирал



Банкуудын хангалттай хэмжээний өөрийн хөрөнгөтэй байна.

Банкууд эдийн засгийн өсөлтийг дэмжих, гол салбаруудын өсөлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зээл олгох хангалттай өөрийн хөрөнгөтэй байна.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн III улирал



Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж

16%

2023	2024	2025	2023	2024	2025	2023	2024	2025	2023	2024	2025	2023	2024	2025
Хуан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий
банкуудын хөрвөх чадварын
харьцаа үзүүлэлтийн дундаж


36%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Системийн нөлөө бүхий 5 банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Банкууд цаашид эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хангалттай хэмжээний хөрөнгөтэй байна.

Банкнүүдн хөрвөх чадварын харьцаа, жил бүрийн III улирал



2023	2024	2025
Хаан		
2023	2024	2025
ХХБ		
2023	2024	2025
Голомт		
2023	2024	2025
Төрийн банк		
2023	2024	2025
Хас		

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2025 оны III улирал: Эдийн засгийн өсөлт 5.9 хувьтай гарлаа. Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан хүндрээд байсан хөдөө аж ахуйн салбар он гарсаар сэргэж буй нь эдийн засгийн өсөлтийн дийлэнх хэсгийг бүрдүүлэв. Боловсруулах, барилгын салбарын алгуур сэргэлт нь эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал нөлөө үзүүллээ. Уул уурхайн салбарын өсөлт нь хүлээлтээс доогуур байж түүнийг дагасан худалдаа, тээврийн салбар унасан нь эдийн засгийн өсөлтийг хойш нь татав.


Төлөв байдал: Гадаад орчны эдийн засгийн тодорхой бус байдал ирэх жилүүдэд ч үргэлжлэх төлөвтэй байна. Ирэх 2026 онд уул уурхайн бүтээгдэхүүнээс олох орлого, татварын орлогыг өөдрөг төсөөлж суурь цалингууд, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхээр төсөвт тусгасан нь валютын ханш, төлбөрийн тэнцэл болон инфляцад дарамт учруулах эрсдэл өндөр байна. Уул уурхайн болон уул уурхайн бус салбарын төрөлжилт, бүтээгдэхүүний төрөлжилтийг хийхэд чиглэсэн бодлогын арга хэмжээ нь манай улсын эдийн засгийн хамгийн чухал хэсэг хэвээр.

2025 оны III улирлын байдлаар эдийн засаг 5.9 хувиар өсөв.

Хүндхэн найман улирлын дараагаар ХАА-н салбар сэргэсэн нь эдийн засгийн өсөлтийн 3.4 хувийг дангаар бүрдүүллээ.

Боловсруулах болон барилгын салбарын аажим сэргэлт нь эдийн засгийн өсөлтийг дэмжиж 0.9 хувийг бүрдүүлэв.


Уул уурхайн салбар хүлээлтээс доогуур байсны улмаас түүнийг дагаад худалдаа, тээврийн салбарын өсөлт саарч эдийн засгийн өсөлтийг хойш татав.




Гадаад худалдааны тэнцэл ашигтай хэдий ч өмнөх оны мөн үеэс 31.5 хувиар буурчээ.

Зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдрийн баяжмалын экспорт нэмэгдсэн нь худалдааны тэнцэл ашигтай гарахад чухал үүрэг гүйцэтгэлээ. Нүүрсний үнийн уналт нь экспортын хэмжээ буурахад нөлөөллөө. Хэрэглээний зориулалттай бүтээгдэхүүний импорт нэмэгдсэн хэдий бусад бараа бүтээгдэхүүний импорт буурчээ.


Уул уурхайн гол бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дэх үнэ буурсан нь **экспортын өсөлт** саарахад нөлөөллөө.



Хөрөнгө оруулалтын зориулалттай бараа бүтээгдэхүүний **импорт бууралттай** байна.



Импортын өсөлт нь худалдааны тэнцлийн ашиг буурахад нөлөөллөө.




Төлбөрийн тэнцэл 53 сая ам.долларын ашигтай гарлаа.

Импорт буурч экспортоос олох орлого аажмаар нэмэгдэж буй нь төлбөрийн тэнцэл ашигтай гарахад нөлөөллөө.


Гадаадаас 260 сая ам.долларын хөрөнгө оруулалт татсан нь санхүүгийн данс ашигтай гарахад нөлөөллөө.

Төгрөгийн бодит ханш аажмаар чангарч манай улсын бараа, бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад үнэтэй болж байна.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш



Төлбөрийн тэнцэл



Төсвийн тэнцэл 1.3 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.


Урсгал зардал тэр дундаа цалин хөлс болон бусад бараа бүтээгдэхүүний зардлын өсөлт нь төсвийн зарлагын дийлэнх хувийг бүрдүүлж байна.

Үндсэн тэнцэл ашигтай гарч төсвийн алдагдлын дарамт буурч байна.



Уул уурхайн салбараас олох орлогын хэмжээ буурснаар орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ буурч төсөв алдагдалтай гарахад нөлөөллөө.


Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 3.1%
буурчээ.

ДНБ-д эзлэх хувиар



Төсвийн зарлага өмнөх оны мөн үеэс
11% өсжээ.






Өрхийн орлого үнийн
өсөлтийг гүйцэхгүй
байна

Өрхийн бодит орлогын хэмжээ жил бүр нэмэгдэж буй хэдий ч үнийн өсөлтөөс шалтгаалсан бодит зарлагаа гүйцэхгүй байна.

Нэг өрхийн сарын дундаж орлогын 79 хувийг цалин, тэтгэвэр болон тэтгэмжийн орлого бүрдүүлж байна.

Айл, өрхүүд сарын мөнгөн зарлагынхаа 60 хувийг хүнсний бус бараа, үйлчилгээнд, 16 хувийг хүнсний бүтээгдэхүүнд зарцуулж байна.

Өрхийн сарын бодит орлого өнгөрсөн онтой харьцуулахад **4 хувиар** нэмэгджээ



Өрхийн сарын бодит зарлага өнгөрсөн онтой харьцуулахад **5.1 хувиар** нэмэгджээ.

